



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/44

Хархорин сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 48 дугаар зүйлийн 48.2.4, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны хуралдааны 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтийн дагуу ӨВАХХСЗДТГ/20250102023/01/01 урилгын дугаартай Малын тэжээл тариалах тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн 1 дүгээр багцыг 78,818,000 (далан найман сая найман зуун арван найм) төгрөгөөр Өндөр хуримт ХХК-иар, 2 дугаар багцыг 99,400,000 (ерэн есөн сая дөрвөн зуун мянга) төгрөгөөр ГООЛ ХХК-иар тус тус гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Лхагвадулам)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Ц.Мягмарсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.БАТ-ЭРДЭНЭ

